

БАЙГАЛЬ ОРЧИНД Ээлтэй Сайн Мэдээ

Ирээдүйн ариун цэврийн цаас модны орцгүй

Ердийн ОО-ын цаас, салфетка, цаасан алчуур болон бусад цаасан ариун цэврийн хэрэгслийг орлуулах модны орцгүй, байгальд ээлтэй бүтээгдэхүүнүүдийг олон компаниуд үйлдвэрлэдэг болоод байна. Мөн байгаль орчинд ээлтэй эдгээр компаниудын ихэнх нь цаасыг цайруулахад ашигладаг хорт хавдар үүсгэж болзошгүй, байгаль бохирдуулдаг химийн бодис болох хлорыг ашигладаггүй байна.

Хэрэв бид модны орцгүй ОО-ын цаас болон бусад модны орцгүй ариун цэврийн бүтээгдэхүүн хэрэглэж хэвшвэл:

- Жилд ойролцоогоор 99 сая мод тайрахыг зогсооно
- Дэлхийн дулаарлыг бууруулна
- Үйлдвэрлэлд зориулагдах маш их хэмжээний усыг хэмнэнэ
- Үйлдвэрлэлд зориулагдах эрчим хүчийг хэмнэнэ
- Агаар болон усны урсацын дагуух бохирдлыг бууруулна (гол мөрөн, нуур, далай зэрэг)
- Өөрсдийн төдийгүй тоолшгүй олон төрөл зүйлийн ургамал амьтны амьдрах орчныг хамгаалж хадгална.

Модны орцгүй ОО-ын цаасыг олон төрлийн материалаар хийж болдог. Ихэвчлэн чихрийн нишингийн шахдас (чихэр гаргаж авсны дараа үлддэг ширхэглэг дайвар бүтээгдэхүүн) болон хулсыг хослуулан хийдэг. Зах зээлд зарагдаж буй зарим хамгийн сайн цааснуудыг үйлдвэрлэхэд эдгээр нь ашиглагддаг шалтгаан нь:

- **ЗӨӨЛӨН** - дахин боловсруулсан олонх цаасан бүтээгдэхүүнүүдээс илүү зөөлөн
- **БАТ БӨХ** - хулс болон чихрийн нишингийн ширхэглэг нь тун бөх
- **ЗАДАРДАГ** - хулс болон чихрийн нишингийн ширхэглэг нь газар шороонд амархан задардаг.
- **ТОГТВОРТОЙ, ТҮРГЭН УРГУУЛАХ БОЛОМЖТОЙ** – хулс болон чихрийн нишингэ нь залаат ургамлууд бөгөөд түргэн ургадаг: хулс сард 100 инч ургах боломжтой, нишингэ сард 12 инч ургадаг, гэтэл мод сард ердөө 2 инч ургадаг. Хулсны тайрагдсан иш нь хэдэн сарын дараа өөрөө эргэн ургадаг тул дахин суулгах шаардлагагүй байдаг.
- **БОЛОВСРУУЛААГҮЙ ШИРХЭГЛЭГ** - хулс болон нишингийн бүтээгдэхүүнүүдэд дахин боловсруулсан цаасны адил нүсэр их цайруулалтын бэх, будаг шаардагддаггүй.
- **БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ** - нишингийн шахдас нь өргөн олдоцтой байдаг ч олонх тохиолдолд хаягдан, шатаагдаж улмаар агаарт бохирдол үүсгэдэг. Тиймээс цаасны оронд нишингийн шахдасыг ашиглах нь хаягдал болж, шатаагдахаас сэргийлэх болно.

Та мэдсэн үү?

Дэлхий даяар ОО-ын цаас нь дангаараа өдөрт 27.000 модыг устгадаг! Энгийн ОО-ын цаас нь мөнгөн ус, диоксин, ВРА болон ВРС хэмээх байгаль орчин бохирдуулдаг, хорт хавдар үүсгэдэг зэрэг эрүүл мэндэд хортой химийн бодис агуулж байдаг.



Хулс (дээд талын зураг) болон чихрийн нишингийн иш

Нимбус Эко зэрэг зарим компаниуд хулс болон нишингийг тарьж ургуулан, гараар хураан авдаг тул энэ нь хог хаягдал болон нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулдаг болохыг онцолж байна. Хятад улсын Тралин хэмээх шагнал хүртсэн нэгэн үйлдвэрлэгч хаягдах байсан үр тарианы ургацын ишийг хэрэглэдэг байна.

Ирээдүйд бид цэцэрлэгжүүлж, зүлэг, буудай зэргийг тайрч үлдэгдлүүдийг шатаахын оронд тэдгээрийг ашиглах нь гарцаагүй хэмээн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хэлсэн байна.

Модны орцгүй цаас хэрэглэх нь байгаль орчинд ээлтэй байх нь дамжиггүй (бидний эрүүл мэндэд ч мөн адил)!

Бидний мэдэх модны орцгүй цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудыг доор жагсаав.

Өөрийн тань оршин суугаа газарт ийм үйлдвэрлэгч байгаа эсэхийг судлаарай.

Shandong Tralin Group (Хятад)

<http://en.tralin.com>

Ашиглах материал: Сүрлийн зөөлөн эд

Цайруулагч

Caboo (Канад болон АНУ)

www.caboopaper.com

Ашиглах материал: Нишингийн шахдас, хулс
Устөрөгчийн хэт исэл, хлоргүй цайруулагч
хэрэглэдэг

Kcrown Green Choice (Австрали)

www.kcrown.com.au/greenchoice/index.html

Ашиглах материал: Нишингийн шахдас, хулс

Хлор хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй

Nimbus Eco (Amazon.com-оос захиалах боломжтой)

www.nimbuseco.com

Ашиглах материал: Нишингийн шахдас, хулс
Хлоргүй цайруулагч

Ology (АНУ; Зөвхөн Walgreens-н дэлгүүрүүдээр худалдаалдаг)

www.walgreens.com/q/ology

Ашиглах материал: Нишингийн шахдас, хулс
Устөрөгчийн хэт исэл, хлоргүй цайруулагч
хэрэглэдэг

Green2 (АНУ болон Канад)

www.truegreen2.com

Ашиглах материал: Нишингийн шахдас, хулс
Устөрөгчийн хэт исэл, хлоргүй цайруулагч
хэрэглэдэг

Kora (Amazon.com-оос захиалах боломжтой)

<http://korabrand.com>

Ашиглах материал: Хулс

Хлоргүй цайруулагч

Green Soft - Saved a Tree (Австрали)

www.savedatree.com.au

Ашиглах материал: Хулс, сүрэл, зэгс,
хөвөнгийн ургамал
Хлор хэрэглэдэг эсэх нь тодорхойгүй...

...Цааш үргэлжилнэ!

Мэдвэл зохих цайруулагч нэршлүүд

TCF (Огт Хлоргүй)

Хлор болон түүнтэй холбоотой бодисуудыг ашиглаагүй.

Өргөн хэрэглэгддэг TCF цайруулагч: Устөрөгчийн хэт исэл.

PCF (Боловсруулахад хлоргүй хэрэглээгүй)

Ямар ч хлоргүйгээр дахин боловсруулагдсан цаас хэдий ч анхдагч цаас нь хлороор цайруулагдсан байх

ECF (Үндсэн хлор агуулаагүй)

Хэдийгээр хлорын хий ашиглаагүй ч хлортой холбоотой бодисуудыг ашигласан, диоксин зэрэг хорт бодисуудыг бууруулсан ч бүрэн арилгаагүй.

Бидэнд энэхүү мэдээллийг хуваалцах зөвлөгөө өгч Цаас Ашиглах Эко Аргууд Илгээмжийг хэрэгжүүлэх урам зориг өгсөн Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай танд баярлалаа.

Эрдэнэт гариг дэлхийгээ хамгаалж, ирээдүй хойч үедээ илүү амьдарч болохуйц, үзэсгэлэнтэй гэр бий болгоход бид бүгд өөрсдийн хувь нэмрээ оруулах болтугай!